

ОРОСЫН ЭЛЧ НАРЫН XVII ЗУУНЫ ТЭМДЭГЛЭЛ ДЭХ ЗАРИМ ГАЗАР УСНЫ НЭРИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭ

С.Чулуун

Оршил

Монголын газар усны нэрийн тухай судалгааг өргөжүүлэхэд архивын баримт, түүхийн сурвалжаас гадна анхааран авч үзүүштэй баримт бол үе үед монголд ирсэн элч нарын тэмдэглэл юм. Тиймийн учир миний бие эдүгээ 17 зууны туршид Монголд ирсэн 20 гаруй элч нараас хэдэн элчийн тэмдэглэлийг анхааран үзэж дурдагдсан газар усны нэрийг хайж тодруулах, тэнд болсон түүхэн үйл явдал, ноёдын эзэмшил нутгийн зааг цэсийг тодруулахыг хичээсэн болно. Мэдээж олон элч нар буй боловч тодорхой хэдийг нь сонгосон нь цагийн хугацаанаас хамаатай. Харин элч нарын тэмдэглэлд дурдагдсан нэлээд газар нутгийн миний бие өөрийн биеэр хайж сураглаж тодруулах хээрийн судалгааг Монгол болон ОХУ-ын Тува улсын газар нутагт 3 удаа явуулж нэлээд баримт, аман мэдээ занги цуглуулж, тодруулах оролдлого хийсэн болно.

Мэдээж Оросын элч нарын тэмдэглэл нь зарим өмнө нийтлэгдсэн зарим нь нийтлэгдээгүй баримтууд ч бас буй. Тухайбал Оросын Холбооны Улсын Москва хотын Эртний улсын Архивын сан хөмрөгөөс олж илрүүлсэн юм.

Уг судалгааг хийхэд гүн туслалцаа үзүүлсэн ОХУ-ын Тува улсын Боловсрол, ШУ-ны сайд К.А.Бичилдэй болон Тувагийн хүмүүнлэгийн хүрээлэнгийн залуу эрдэмтэн Б.Баярсайхан, Увс аймгийн Давст сумын харъяат н.Дэлгэржав, Завхан аймгийн Тэс сумын Байгаль орчны байцаагч н.Баярсайхан зэрэг хүмүүст нэн талархал илэрхийлэх хэрэгтэй.

Оросын элч нарын зам ба газар усны нэрс

Оросын Монгол нутагт зорин ирсэн элч нарын замын чиглэлийг хэд хэдэн чиглэлд хуваан авч үзэх ч 1650-иад оны эцэс хүртэлх хамгийн гол замын нэг нь хожмын Хотогойдуудын Алтан хааны улс хэмээн алдаршсан Шолой Убаши хунтайжаас Лувсан Эринчин сайн хун тайж хүртэлх үеийн ноёдуудыг зорьсон элч нарын зам байлаа. Товхондоо хэлэхэд Алтан хааны улсад хүрэлцэн ирсэн элч нарын замын чиг баримжааг судлаачид эдүгээ хүртэл тодруулсан нь бараг үгүй юм. Москвагаас гарсан элч нар Сибирийн ууган хотуудын нэг Томск хотоор дайран Абакан голыг хүртэл яваад тэндээс одоогийн Тувагийн нутгийг дамжин Увс нуурын ай сав дахь Алтан хааны улсад айлчилан ирж байсныг зарим элчийн тэмдэглэлээр тодруулахыг хичээв. Энэ нь хэдийгээр энгийн мэт боловч Оросын элч нарын дорно зүгт тавьсан зам, түүний чиглэлийг тодорхойлоход ихээхэн чухал юм. Мэдээж энэ чиглэлийн замаар ирсэн 20 орчим элч нарын тэмдэглэл бүр янз янз учир явсан газар бүрийн чиг баримжаа тийм ч тодорхой бус юм. Бие биенээ нөхсөн шинж байдалтай юм. Анхны элч Тара хотын атаман В.Тюмениц нарын элчээр явахдаа тэмдэглэсэн “*мэдүүлгийн бичиг*”-г анхны ерөнхий баримжаа газар усны нэрсийг тэмдэглэснээс хойш тодорхой тэмдэглэсэн *Томск хотын алмудын боярын хүү С.Греченин ба дэд албан хаагч А.Самсонов, 1638 онд ирсэн Томскийн В.Старков нарын тэмдэглэлд нэр гарах “Абакан гол, Хэмчиг гол, Саяны хадан уул, Ак кол, Чеган механ, Алас, Кундэлэн, Хантыгэр, Жиргату, Ядан, За кол, Чекур*

С.Чулуун

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн
samchuluun@gmail.com

С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал

“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

булак”¹ зэрэг газрыг туулан Увс нуур, Хэмчиг голын сав нутаг дахь Алтан хааны улсад хүрч байсныг мэдэж болно.

Чухамдаа дээр нэр дурдагдах газар усны нэрс нь одоогийн Абакан голын сав нутгаас Саяны нурууг даван Увс нуурын ойролцоо ирэх замд орших өнөөгийн ОХУ-ын Тувагийн Бүгд найрамдах улсын нутаг дэвсгэрт оршино. Эдгээр газар нутгийг зөв олж тогтоовол Оросын элч нарын Монгол нутагт ирсэн замын чигийг баримжаалахаас гадна тухайн үеийн Монгол болон Соён, Хэмчигийн сав нутаг дахь бусад уугуул нүүдэлчдийн тархац, нутагшилт зэргийг тодорхойлох боломж давхар бүрдэнэ.

Анх 1617 онд Шолой Убаш хун тайжтай ирж уулзсан Тара хотын атаман В.Тюмениц нарын тэмдэглэлд

“Томск хотоос хамгийн түрүүнд тааралддаг гол нь Чя, дараа нь Кыя гол, дараа нь Урюпа гол, дараа нь Июс гол, Енесея гол байдаг. Киргизд Аскис гол, Обакан гол байдаг. Чястые Броды гол чулуун ангалаар урсдаг ба энэ ангалаар 3 хоног мориор явна. Мөн Кантери гол, Кемчига гол урсдаг. Кемчига голын дагуу Алтан хаан нүүдэллэдэг.

Бид нэг нуурын дэргэдүүр явсан ба тэр нуурын нэр нь Усап, хажуудах уул нь давстай, бөгөөд нэрийг нь Кукей гэдэг”²

хэмээн тэмдэглэсэн байна. Энд нэр гарах Кантери бол одоогийн Тувагийн баруун Хэмчиг, Сут көл хоёр хошууны заагт орших “Хан дээр” буюу “Хан тэнгэр” хэмээх уулын гол бөгөөд тэрээр өмнө зүгт уруудан урсаж Хэмчиг голд “Алдын мадыр” сумын нутгаар нийлж байна. Уг тэмдэглэлд Соёны нуруунаас Мат нарын нутаг хүртэл 8 хоног явна гэж тэмдэглэсэн ба Матууд үндсэндээ Хэмчиг голын урд тал Мөнгөн тайгын зүүн биеэр нутаглаж байсан мэт байна. Эдүгээ ч Тувагийн Мат овгийнхон нар тэнд голлон сууна. Матын нутаг хүртэл хэд хэдэн голыг туулах бөгөөд тэдгээр голуудын заримыг нь өөр бусад элч нарын тэмдэглэлээс оочин цоочин мэдэж болно. Эдгээр голын нэрс нь дээр дурдсан газар усны хэдэн нэр юм. Элч нарын тэмдэглэлээс Абакан голоос Хэмчиг гол хүртэл нийт 10 орчим хоног явж хүрэх тухай бараг ихэнхи нь ижил тэмдэглэсэн байна.

“Абакан гол, Хэмчиг гол, Саяны хадан уул, Ак кол, Алас, Кундэлэн, Хантыгэр, Жиргату, Ядан, За кол, Чекур булак” зэрэг газар усны нэрийг эдүгээ хэрхэн өөрчлөгдсөн байршилыг тодорхойлох зорилгоор 2013 оны 9 сард миний бие Енисейн сав нутаг хүртэлх газарт Соёны нурууны баруун биеэр тойрч ажилласан юм. “Идан” хэмээх голыг “Чадан” мөн гэж үзвэл уг голын баруун биед орших Жиргаг хэмээх гол байна³. Үүнийг 1638 оны 10 сард Омбо-Эрдэнэтэй уулзахаар ирсэн В.Старковын тэмдэглэлд бичсэнээр Жиргату гол⁴ нь Хэмчиг голын өмнө биед байсан нь тодорхой. Тэндээс хойш орших “хан дээр” буюу “Хан тэнгэр” гол болоод уулын нэр эдүгээ хүртэл хэвээр байна. Уг газрын байцыг бас дараахь байдалтай тэмдэглэсэн байна.

“Тэгээд Чеганмахаас Саяны их хаднууд руу орсон ба энэ хад хүртэл Абаканаас нийт 4 өдөр авирав. Тэдгээр хаднаас Кантыгир гол руу уруудав. Кантыгир гол эгц эрэгтэй, аятайхан тэгш талбай байхгүй бөгөөд шууд Саяны хаднуудаас доошоо бууна. Тэр голыг баруун эргээс нь зүүн эрэг хүртэл нь туулахад ус хүний мөрөнд хүрэхээр гүнзгий байсан ба тэгээд Кантыгири голоос уулын орой хүртэл 2 өдөр явав. Тэр голоос Саяны өөр нэг хаднууд руу авиран гарч, хаднуудынхаа дээд замаар баруун гар тийш эргэн доош уруудаж, дараа нь гурав дах, арай намхан хэсэг хадан дундуур явж өнгөрөв”⁵ хэмээн тэмдэглэжээ. Газрын байцын хувь авч үзвэл энэ газар нь Соёны нурууны ихээхэн бэрх зам болно. В.Старков нар чухамдаа яагаад энэ бэрх замаар шууд давсан тухай тодруулах мэдээ байхгүй боловч 1637 он, 1659

¹ Материалы по истории русско-Монгольских отношений. Сборник документов. 1636-1654. Составители М.И.Гольман., Г.И.Слесарчук. Москва. 1974. стр 105-106.

² Материалы по истории русско-Монгольских отношений. Сборник документов. 1607-1636. Составители Л.М.Гатауллина. М.И.Гольман., Г.И.Слесарчук. Москва. 1959. стр. 61.

³ 2013 оны 9 сарын 15-21-нд Тува, Хакасын нутагт ажилласан судалгааны тэмдэглэлээс.

⁴ Материалы по истории русско-Монгольских отношений. Сборник документов. 1636-1654. Составители М.И.Гольман., Г.И.Слесарчук. Москва. 1974. стр 106.

⁵ Материалы по истории русско-Монгольских отношений. Сборник документов. 1636-1654. Составители М.И.Гольман., Г.И.Слесарчук. Москва. 1974. стр 105.

онуудад ирсэн элч нарын тэмдэглэлээс үзвэл Соёны нурууны ерөнхийдөө баруун биеэр саад бэрхшээл арай багатай газар нутгаар дамжин Хэмчиг голын савд хүрч иржээ. Хан тэнгэр уулын араас барууншлан Алас буюу одоогийн Алаш голыг уруудан орж ирсэн нь тухайн үеийн цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан замаа өөрчилсөн байна. Ялангуяа Томскийн С.Гречениний тэмдэглэлд уг замын тухай дараах мэдээг өгч байна.

“Ака голын эрэгт 3 хоноод, 4 дэх өдөр нь Коке-Котел гэдэг том уулыг даваад, Алас гол руу бууж ирээд, өдрийн гуравны нэг хугацаанд яваад Конделень голд хүрч ирэхэд Кемчик голд арай хүрээгүй байв” гэж тэмдэглэжээ. Уг тэмдэглэлд дурдагдаж буй газар усны нэрс эдүгээ бараг бүгд энэ бүс нутагт арай өөр дуудлагаар Алас голыг Алаш, Конделень голыг Кундэлэн гэх мэтээр нутгийн тувачууд нэрийдэж байна.

Тэдний дамжин өнгөрсөн газар нутгийн нэрсээс үзвэл:

“Хааны улсаас гараад бид Кемчюкийг өгсөн явж, Кемчюк голын зүүн гараар явж Барла гол руу хүрч, тэр голын эх хүртэл яваад, уулын оройн чулуун дундуур явж өнгөрөн Урюча нуур руу очиж, тэндээсээ хадан дундуур гарч, Алатери буюу Пегое нуур руу очив. Энэхүү нуурын эрэг хавийн нутгийг мөн Алтан Кедус (Алтан гадас) буюу оросоор Золотой прикол гэж нэрлэдэг. Энэ нууранд олон гол цутгадаг боловч энэ нуураас эх авсан ганц ч гол байхгүй” гэж тэмдэглэжээ. Энд нэр гарч буй хэдэн нуурыг бид тодорхойлж чадсангүй. Хан тэнгэр уулын өмнө Сут кел буюу сүүн нуур гэдэг уулын орой дээрх нэг нуур байна. Бор хайрханы ард талд.

Ноёдын нутагшилт ба газар усны нэрс

Оросын архивын баримтад буй элч нарын замын тэмдэглэлээс тухайн үеийн Монголын ноёд язгууртнуудын нутагшилт зэргийг тодруулах боломжтой мэдээлэл бас буй. Бид жишээ болгож хэдэн нүүдлийн тухай мэдээлэл оруулав.

1647 онд Сэцэн хааныд ирсэн К.Москвитиний тэмдэглэлд:

“Еравна нуураас Мунгал газар руу явсан зам Мунгалын хаан Чичин² ван Турокай табунаны³ нутаг руу орох ба Мунгалын эхний улс руу хүрч очиход нэг өдөр явна. Энэ улсын ван нь Тулук Селенга, харин Тулук Селенгийнхээс Турокой вангийнх хүртэл нэг өдөр явна, харин Турокойгаас Дергоус вангийнх хүртэл бас нэг өдөр, харин Дергоус вангийнхаас ван Кутыхтынх хүртэл нэг өдөр явна, Кутухтынхаас Катуней ван хүртэл нэг өдөр, Катунейгаас Уда голын гарам хүртэл бас нэг өдөр явах ба Уда голыг гатлаад доош уруудахад Селенге гол хүрэх ба гармаас Селенге хүртэл 3 өдөр явна. Харин Уда гол том бөгөөд гүнзгий бөгөөд тэр голоор янз бүрийн усан онгоцоор явж болдог ба Селенге мөрөнд цутгадаг. Тэгээд Селенге мөрнийг гатлана. Харин гарам дээр хүн олон бөгөөд бүгд мунгал хүмүүс. Мөн Селенге мөрөн том нэг эргээс нь нөгөө эрэг рүү хашгирахад хүний дуу сонсогдохгүй, том онгоц, ер нь жижиг онгоцоор ч явж болохгүй. Учир нь урсгал нь хурдан бөгөөд гол гүехэн арал, ба уурхай руу урсан орж ирдэг, мунгал хүмүүс энэ голын дагуу нүүдэллэдэг. Селенге мөрөн Байгаль нуурт цутгадаг. Харин Селенге мөрөн хаанаас эхтэйг мунгалууд хэлээгүй ажээ. Харин Селенге мөрний гармаас эхлээд тал дундуур Богатыр вангийнх хүртэл нэг өдөр явна. Мунгал хүмүүс түүнийг Богатырь гэсний учир нь түүний хүмүүс биш өөрөө хүчтэй болохоор тэгэж нэрлэжээ. Харин Богатырь вангийнхаас Түшээт вангийнх хүрэхэд нэг өдөр явна”⁶ гэж тэмдэглэсэн байдаг бол 1659 оны намар өвлийн заагт Алтан хаан Лувсангийнх ирсэн элчийн тэмдэглэлд:

“3-р сарын 30-нд тэрхүү нутгаас Тесе гол руу нүүхдээ асар том Упса нуурын дэргэдүүр явж өнгөрсөн ба амарсан хугацаагаа оруулалгүйгээр 9 өдөр нүүв. 4-р сарын 12-нд асар том Упса нуураас Амтытай гол руу нүүв. 4-р сарын 16-нд Амтытай голоос дээш өгсөн Хар ус нуур руу нүүв. 4-р сарын 22-нд Хар ус нуураас Тес гол руу нүүв” гэж тодорхой тэмдэглэжээ. Миний бие мөн энэ тэмдэглэлийн дагуу Тэсийн сав нутаг, ОХУ-ын Тувагийн БНУ-ын Эрзин, Нарийн гэсэн хил орчмын нутаг, Завхан аймгийн Тэс сумын нутгаар явж сурвалжилсан юм. Гэвч одоо Амттай хэмээх нуурыг аль болохыг энэ удаад тогтоож чадсангүй. Хар ус нуур, Увс

⁶ Материалы по истории русско-Монгольских отношений. Сборник документов. 1636-1654. Составители М.И.Гольман., Г.И.Слесарчук. Москва. 1974. стр 316.

нуур, Тэсийн савд хаваржааны нүүдэл ямар хэмжээтэй болохыг мэдэж авав.

1677 онд Түшээт хаан, Өндөр гэгээн нартай уулзахаар ирсэн Ф.Михайловский нарын тэмдэглэлд Түшээт хаан нарын нүүдлийн тухай уг тэмдэглэлд”

“Тэгээд 1-р сарын 7-нд Очирой хаан Таран гул хэмээх нутгаасаа Зим Бадарха зайсаныг явуулж, биднийг тэр газраас өөр нэг шинэ газар руу Кокконо уулын чулуу руу нүүлгэх тушаал өгсөн”⁷ гэсэн байна. Таран гул гэдэг нь өнөөгийн Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг Тарни гол ба Хөгнийн уулс нь Хөгнө хан болно. Үүнээс 4 жилийн дараа ирсэн одоогийн Улаанбаатар хот орчимд нутаглаж байсан тухай 1681 оны 6 сард ирсэн Тобольскийн Боярын сын В.С.Турскийн тэмдэглэлд

“Василей Турский Селенгинскийн цэргүүдийн хамт 6-р сарын 2-нд Селенгинскээс гарч явжээ. Тэгээд Василей би болон миний нөхөд тагалцар хэмээх газар ирж, тэр өдрөө очив. Тэр голын ойролцоо табунун тайш Цокулаев, Заба Ирденийн хүмүүс болох шуленг Гадай, Тагай нар нөхдийнхөө хамт нийт 150 орчим хүнтэйгээ нүүдэллэн явав... 6-р сарын 10-нд Шар гол дээр ирэхэд тэр голын хоёр эргээр Цыбден тайшийн хүүхдүүд өөрсдийн улсуудынхаа хамт нүүдэллэн явав. Тэгээд Битигей голыг гаталсан ба тэр голын эрэгт Хутагтын тариа тарьдаг мугалууд байв. Мөн тэр Битегей голын адаг хавийн нугад 2 жижиг хотхон байсан ба Селенгинскээс гарсан хүн тэдгээр хотхонуудаас гарч зүүн гар талаа барин явбал Цыбден тайшийн хүү өөрийн хүмүүстэйгээ нүүдэллэн явдаг ба нийт 30 орчим айл байв. 6-р сарын 11-нд Борой гол ирж, гатлаад Арангат гол руу очтол Цыбден контайштай өөртэй нь тааралдав. Харин Цыбден Хутугтынхаас явж байсан ба тэр голоос 3 хоног яваад Хутагтынх байгаа гэв. Тэгээд Цыбден контайш Василья Турский ба цэргүүд рүү 2 хүнээ явуулсан ба энэ хоёр хүний нэг нь Цыбдений авга ах Салагай манзи, нөгөө нь Суенк гэдэг ажээ. Тэгдээд Цыбден контайш биднийг энэ голын эрэгт өөрийндөө хоноглоно уу гэв. Бид тэднийд хонов. 6-р сарын 12-нд Кунцалак хэмээх нуурын дэргэдүүр гарч, Бургатай гэдэг газар ирсэн бөгөөд энэ голын эрэгт Очирой сайн ханы хүмүүс байсан ба тэдэнтэй хамт Илден Обоси хэмээх шилдэг байв. 6-р сарын 13-нд Куй голыг гаталсан” гэх мэтээр нарийн тэмдэглэсэн байна. Түүний тэмдэглэлд Сэлэнгээс хэрхэн одоогийн Улаанбаатар буй Хан уул, Хатан туулын савд явж ирснийг шууд мэдэж болохоор байна. Шарын гол, Бургалтай гол, Битүүгийн гол, Улиастай, Туул, Сэлбэ зэрэг голын нэрс тодорхой гарч байна. Тэр үед Түшээт хаан Чахундорж, Өндөр гэгээн Занабазар нар Цагаан нуга, Туулын хөндий Бичигт хэмээх газарт нутаглаж байсан аж.

Энэ мэтчилэн 17 зууны туршид Монгол нутагт хүрэлцэн ирсэн Оросын элч нарын тэмдэглэлд дурдагдаж буй олон арван газар усны нэрийг сайтар нягтлан судлах юм бол тухайн үеийн түүхийн олон мэдээг тодорлуулах бүрэн боломжтой. Түүгээр зогсохгүй архивын болон түүхийн сурвалжийн мэдээг нөхөх, тодруулах, газар усны нэр судлалд үнэтэй мэдээлэл болно. Мэдээж Оросын элч нар бол монгол хэл мэдэхгүй учир эндүү ташаа тэмдэглэсэн бөгөөд алдсан эндсэн, буруу ташаа тэмдэглэсэн зүйлс буйг анхаарах хэрэгтэй болов уу. Түүнээс гадна тухайн үед Оросуудтай харилцаж байсан элчин харилцааны энэхүү мэдээлэл монголын түүхийн судлалын нэгэн чухал асуудлыг тодруулах, түүхэн үйл явдал, ноёд хоорондын харилцааг мэдэж таних, нийгмийн зохион байгуулалтыг ойлгож мэдэхэд нэлээд чухал мэт санагдаж байна. Оросын элч нарын тэмдэглэлээс гадна тухайн үед эдгээр элчийг дагуулан Оросд илгээж байсан элч нарын авч явсан захидал бичгүүдэд мөн гаар усны нэрс нэлээд гарах бөгөөд Монголчууд өөрсдөө хэрхэн нийдэж байсныг тодруулах боломжтой. Ийнхүү Монгол нутагт хааны зарлигаар томилогдон ирсэн элч нарын тэмдэглэл нь тухайн үеийн түүхийг судлах чухал эх сурвалжаас гадна “Монголын түүхэн газарзүйн” судалгаа, газар усны нэр судлал (*топонимик*)-ийн судлалд чухал гэж үзэж болно. Эдгээр элч нарын явсан зам, тэмдэглэгдсэн газар нутгийг тусгайлан судлаж түүний дагуу түүхэн газар зүйн хайгуул судалгааг хийж харьцуулан үзэх судалгааг өргөтгөн авч үзэх болно.

⁷ Материалы по истории русско-Монгольских отношений. Сборник документов. 1654-1685. Составители Г.И.Слесарчук. Москва. 1996. стр. 312.



Алтан хаадын голомт нутаг



Цагаан бургасын гол



Тэс голын сав нутаг



Тэсийн голын хөндий